

# ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 09 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.09.22

*Газрын удирлагын хэлтсийн чиглэлээр:*

Газрын төлбөрийн орлогын мэдээг сар бүр гаргаж татварын хэлтэст хүргүүлдэг бөгөөд 08 дугаар сарын 31-ний байдлаар 71.47 сая төгрөг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 73,4%-ийн биелэлттэй байна.

| №                  | 01 сар | 02 сар   | 03 сар  | 04 сар  | 05 сар | 06 сар   | 07 сар | 08 сар  | 09 сар  | Нийт     |
|--------------------|--------|----------|---------|---------|--------|----------|--------|---------|---------|----------|
| иргэн              | 227112 | 294838   | 291600  | 618323  | 24747  | 399660   | 221929 | 123688  | 115564  | 2317461  |
| аан                | 293000 | 19985476 | 4014994 | 7115578 | 415800 | 18223532 | 441900 | 8259550 | 6982950 | 65732780 |
| Төсөвт байгууллага | 198000 | 0        | 0       | 341423  | 94676  | 1209571  | 0      | 990380  | 591208  | 3425258  |
| Нийт               | 718112 | 20280314 | 4306594 | 8075324 | 535223 | 19832763 | 663829 | 9373618 | 7689722 | 71475499 |

Газрын даамлуудад газрын төлбөрийн орлогын дэлгэрэнгүй хуулгыг 08 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар гарган өгч бүртгэл хөтлөн ажиллахыг зөвлөсөн. Мөн сумын хэмжээний газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гарган ирүүлсэн боловч хангалтгүй байгаа тул дахин гаргаж ирүүлэхийг зөвлөн ажиллаж байна.

*Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт:*

Баянтал сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/24, 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/37 дугаар захирамжуудыг үндэслэн 4 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулагдаж 568800 төгрөгийг 09 дүгээр сарын байдлаар орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээд байна.



Мөн аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/228 дугаар захирамжийг үндэслэн 3 байршилд дуудлага худалдааг цахимаар зохион байгуулахаар зарыг зууны мэдээ сонины 09 дүгээр сарын 01 болон 18-ны дугааруудад тус тус нийтлүүлсэн. Мөн цахим бирж, байгууллагын вэб сайтанд байршуулан ажиллаж байна.

| № | Төрөл                       | Мөр                                | Газрын төлбөр                      | Дүн                            | Бүртгэл                            | Тайлбар                            |
|---|-----------------------------|------------------------------------|------------------------------------|--------------------------------|------------------------------------|------------------------------------|
| 1 | Ажлын газар, дотоодын газар | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Дүн: 1/100 м-ийн газрын төлбөр | Бүртгэл: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр |
| 2 | Ажлын газар, дотоодын газар | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Дүн: 1/100 м-ийн газрын төлбөр | Бүртгэл: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр |
| 3 | Ажлын газар, дотоодын газар | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Дүн: 1/100 м-ийн газрын төлбөр | Бүртгэл: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр |
| 4 | Ажлын газар, дотоодын газар | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Дүн: 1/100 м-ийн газрын төлбөр | Бүртгэл: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр |
| 5 | Ажлын газар, дотоодын газар | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр | Дүн: 1/100 м-ийн газрын төлбөр | Бүртгэл: 1/100 м-ийн газрын төлбөр | Тайлбар: 1/100 м-ийн газрын төлбөр |

Сүмбэр суманд аялал жуулчлалын зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахаар зарлагдсан бөгөөд 2017 оны 09 дүгээр сарын 28-ний өдөр явагдана.

Газар чөлөөлөх ажилтай холбоотойгоор эхний ээлжинд 3-р багт хонхор хотхонд зөвшөөрөлгүй барьж, буулгасан /гараж, контейнер, амбаар/ зэрэг 7 байршлын 29 объектын газрын чөлөөлүүлэхээр хугацаатай албан мэдэгдэл холбогдох эздэд нь өгч ажилласан бөгөөд үүнээс 1 иргэн 5 дугаар байрны урд талаас 1 амбаарыг чөлөөлөөд байна.



Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс харъяа алба, хэлтэс, газруудын "Нээлттэй хаалганы өдөр"-ийг 2 дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагаанд 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хамрагдан оролцсон.

#### *Нээлттэй хаалганы өдөрлөгөөр*

Газрын харилцааны чиглэлээр: нийт 15 иргэнд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлээ. Үүнд:

- Газар эзэмших эрх шилжүүлэх өргөдөл 1 аж ахуйн нэгжээс;
- Газар хэмжүүлэх өргөдөл 4 иргэнээс;
- Газрын төлбөр төлөх нэхэмжлэх 3 иргэнд өгч, ирэх онд иргэн бүрт өмчлүүлэх газрын төлөвлөгөө, болон бусад мэдээллээр 15 иргэнд үйлчиллээ.



#### *Барилга, хот байгуулалтын чиглэлээр:*

- 2017 оны 3,4-р улиралд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасаны дагуу Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг байнгын ашиглалтад хүлээн

авахад хамтран ажиллах саналыг ГЗБГЗГазарт албан тоот хүргүүлэхээр төлөвлөөд байна.

- Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах судалгааг хийж байна.

- Сүмбэр сум, 1-р баг, Өрхийн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлын зураг төслийг хянаж баталсан.

- Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад өөрчлөлт шинэчлэлтийг хэрхэн хийх зэрэг ойлголтыг аймаг сумдын ИТХурлын дарга, Засаг дарга нарт, газрын даамлууд, бусад холбогдох хүмүүст ГЗБГЗГазартай хамтран 2017 оны 11 сард сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн судалгаа БМ19, орон сууцны борлуулалтын мэдээ зэргийг 3 дугаар улирлын байдлаар, 2014-2017 онд байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн судалгааг тус тус гарган БХТөвд хүргүүлсэн.

- Аймгийн ОНӨҮГазрууд, БЗӨБ ЦТС ТӨХКомпани, ТЗ-н Орон сууцны 2-р анги зэргээс өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээг 14 хоног тутамд гаргуулан нэгтгэж ХОХБТХэлтэст хүргүүлж №1, 2 тайланг хүргүүлэн ажиллаж байна.

- Аймгийн хэмжээнд “Барилгачдын зөвөлгөөн”-ийг 2017 оны 09 дүгээр сарын 22-нд тэмдэглэсэн. Зөвөлгөөний үйл ажиллагаанд Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ЗДТГазрын дарга нар, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, орон нутгийн барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд оролцсон. Мөн 3 хүнийг “Тэргүүний барилгачин цол тэмдэг”, 1 хүнийг БХБЯмны “Хүндэт жуух” бичгээр тус тус шагнасан.

*Ажлынтоохэмжээ, төсөвболовсруулалт:*

- Сүмбэр сум, 3-р баг, 5-р сургуулийн дотуур байрны сантехник, дотор засварын ажлын төсвийг боловсруулсан. Төсөвт өртөг 3,6 сая төгрөг

Ажлын захиалагчийн техник хяналтыг дараах объектуудад хийж, үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд

1. Сүмбэр сум, 3-р абг, 1-р байрны фасад засварын ажил
2. 2 дугаар цэцэрлэгийн цахилгаан хангамж дотор монтаж угсралтын ажил
3. Айл өрх гудамж талбайн хаягжуулалтын ажил
4. Усан спорт сургалтын төвийн засварын ажил
5. Аймгийн төвийг телекамержуулах ажил
6. Баянтал сум 152-р байрны өмнөх тохижилтын ажил
7. Аймгийн төв хогийн цэгийг хашаажуулах ажил
8. Усан хангамжийн ажлыг сайжруулах худаг засварлах шинээр барих ажил
9. Нийтийн эзэмшлийн байрнуудын орцны саравч хүчитгэх, сандал хийх ажил
10. Нийтийн эзэмшлийн талбайн хогийн сав хийх ажил
11. 4.8.11 дүгээр байрны зоорийн давхарын шугамын засварын ажил

#### **АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ФОТО МЭДЭЭЛЭЛ**

1. 1-байрны фасад засвар ажлын гүйцэтгэл 100%

2. 2-р цэцэрлэгийн цахилгаан хангамж

дотор Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтанд угсралтын ажлын гүйцэтгэл 99% техникийн Гүйцэтгэгч: “Вилла бридж” ХХК ажилласан. комисс хүлээн авсан. Гүйцэтгэгч:

“Сүмбэр старлет” ХХК





3.Айл өрх гудамж талбайн хаягжуулах  
Ажлын гүйцэтгэл - 75%  
Гүйцэтгэгч: “Өгөөмөрөн шанд” ХХК  
орд” ХХК



4.Усан спортын төвийн барилгын  
засварын ажлын гүйцэтгэл - 90%  
Гүйцэтгэгч: “Цахир толгойн




5.Аймгийн төвийн телекамерийн ажлын  
гүйцэтгэл - 99%-тай дотоод хяналтын  
Гүйцэтгэл –  
комисс ажилласан.Гүйцэтгэгч: “Би си ти” ХХК



6.Баянтал сумын 152-р байрны  
өмнөх тохижилтын ажил.

70% тай ажилласан.  
Гүйцэтгэгч: “Койт трейд” ХХК




7. Аймгийн хогын цэгийг хашаажуулах ажлын сандал суулгах ажлын гүйцэтгэл - 70%- тай  
Гүйцэтгэгч: "Их зэст хөгжил" ХХК



8. Орны саравчны бэхэлгээ,  
Гүйцэтгэл  
Гүйцэтгэгч: "Суварган говь" ХХК



9. Сүмбэр сум, 3-р баг, 4,8,11-р байрны зоорийн давхарын шугам засварын ажлын гүйцэтгэл 30%-тай хийгдэж байна. Гүйцэтгэгч: "Ус-Ду" ХХКомпани



10. Сүмбэр сум, Усан хангамжийн ажлыг сайжруулах худаг засварлах шинээр барих ажлын гүйцэтгэл 40% - тай, гүний худаг засварынажил 95%-тай, усзөөврийн 2 худгийн ажлын гүйцэтгэл 0%-тай байна.

11. Нийтийн эзэмшлийн талбайн хогийн савны ажлын гүйцэтгэл 65% материал таталт хийгдэж байна.

Барилгын материалын чиглэлээр:

- Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөрийн хүрээнд байгууллагын дотоод нөөц бололцоогоор ГХБХБГ-ын дэргэдэх барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн барилгын суурь, ханын ажил 100 хувь дуусаж, хучилтын ажил 80 хувьтай хийгдэж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР